



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/215

Сүхбаатар сум

### Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "г", Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Урлагийн гавьяат зүтгэлтэн Л.Цэнд-Очирын 105 жилийн ойд зориулж телевизийн "Хөрөг" нэвтрүүлэг хийхэд дэмжлэг үзүүлэх хүсэлтийг түүний охин Ц.Цолмон ирүүлснийг судалж нэвтрүүлэг хийхэд шаардагдах 500,000/ таван зуун мянган/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгийн 500,000 /таван зуун мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.

3. Зардлын тайланг 2020 оны 07 дугаар сарын 30-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүүд тайлагнахыг иргэн /Ц.Цолмон/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ